

Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо



"Тамирчдын харьяалал, шилжилт
хөдөлгөөний" журам



Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо

ТАМИРЧНЫ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ журам

2023 ОНЫ 08 САРЫН 16-НЫ
ӨДРӨЭС ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛНЭ



1. ТАМИРЧНЫ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

1.1 Тамирчны харьяалал, байгууллага клубыг төлөөлөх эрх

1.1.1 МУССХ-ны бүх төрлийн тэмцээнд оролцож байгаа тамирчин МУССХ-ны гишүүн байгууллага, клуб болон хамтран ажилладаг байгууллагыг төлөөлж оролцохоос гадна хувиараа оролцож болно. Аливаа байгууллага клубыг төлөөлөн оролцохын тулд тамирчин нь:

- Тухайн байгууллага, клубынхаа гишүүн байх
- Тухайн байгууллага, клубтээ тасралтгүй нэг (1) сараас дээш хугацаагаар харьяалагдан бэлтгэл сургуулилт хийсэн байна
- Тамирчин нь гадаадад бэлтгэл сургуулилтаа хийж, гадаад улсын клубын давхар гишүүнчлэлтэй байж болно. Харин Монгол улсдаа зөвхөн нэг клубыг төлөөлөн тэмцээнд оролцоно.
- Тамирчин нь ивээн тэтгэгч байгууллагын нэрийг ашиглаж болно.

1.2. Тамирчин харьяалалаа өөрчлөх

1.2.1 Тамирчин өөрийн харьяалдаг байгууллага клубыг өөрчлөхөөр шийдсэн бол энэ талаар өөрийн харьяалагдаж байгаа байгууллага, клуб болон МУССХ-ны ЕНБД-д бичгээр мэдэгдэнэ.

Тамирчин насанд хүрээгүй бол түүний эцэг эх, асран хамгаалагчид өмнөөс нь мэдэгдлийг гаргана. Мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш доорхи шаардлага хангагдсан бол тухайн тамирчин шинэ клубээ төлөөлөн тэмцээнд оролцох эрхтэй болно.

- Тамирчин хуучин харьяалагддаг байгууллага, клуб болон МУССХ-ны ЕНБД-д харьяалал өөрчлөх тухай мэдэгдлээ өгснөөс хойш дор хаяж нэг (1) сар өнгөрсөн байх
- Тамирчин шинэ клубынхаа гишүүн болсон байх

1.3 Тамирчны харьяалалын дүрмийн зөрчил

1.3.1 Харьяаллын талаарх дүрмийг зөрчсөн тохиолдолд МУССХ-ны дүрэм, Ёс зүйн дүрмийн дагуу шалгалтын ажиллагаа явуулж, хянан шийдвэрлэх эрхийг МУССХ-ны Ёс зүйн зөвлөл эдлэнэ.



1.3.2 Ёс зүйн зөвлөл нь Ёс зүйн дүрмэнд заасны дагуу зөрчилд тохирох шийтгэлийг ноогдуулахаас гадна тус тамирчны тухайн тэмцээнд оролцох эрхийг хасах боломжтой. Тамирчны харьяаллын дүрмийг зөрчиж оролцсон тэмцээний бүх шагнал, медаль, оноо, цолыг хураана.

1.4. Тамирчны харьяаллын дүрмийг хэрэгжүүлэх

Энэхүү дүрэм нь 2023 оны 08-р сарын 16 -ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд буцаан хэрэглэхгүй. Тамирчин энэхүү шинэ дүрэм хүчин төгөлдөр болохоос өмнө харьяалалаа өөрчлөх үйл явцаа эхлүүлсэн байсан бол энэхүү дүрмийг хэрэглэхгүй. Шаардлагатай тохиолдолд тамирчин үүнийгээ нотлох үүрэгтэй.